

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНААС ЗОХИОН БАЙГУУЛСАН “ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДАЛ, ЁС ЗҮЙГ ДЭМЖИХ” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 сарын сүүлийн 14 хоногт “ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДАЛ, ЁС ЗҮЙГ ДЭМЖИХ” аяныг харьяа эрүүл мэндийн 16 байгууллагын дунд амжилттай зохион байгууллаа.

Дээрх аяны хүрээнд харьяа эрүүл мэндийн байгууллагууд “Эрүүгийн тухай”, “Зөрчлийн тухай”, “Эмч, эмнэлгийн мэргэжилтний хоорондын харилцаа хандлага”, “Үйлчилгээний ажилтны хандлага”, “Эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагын хэм хэмжээ”, “Утсаар ярих хэл”, “Угтах үйлчилгээ”, “Харилцааны соёл”, “Авлига авах, өгөх шалтгаан”, сэдвээр сургалтуудыг ТББ, холбогдох сургалтын төв, лекторуудтай хамтран зохион байгууллаа. Нийт 4500 гаруй эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан байна.

Соён гэгээрүүлэх байгууллагынхаа ил тод нээлттэй байдлыг иргэдэд хүргэж буй үйл ажиллагааг сурталчилсан дуугүй хөтөч, мэдээллийн самбар, санал хүсэлт мэдээлэл авах хайрцаг ажлуулж байна.



Геронтологийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд “Ёс зүйн дүрмээ хэн сайн мэдэх” АХА тэмцээн, Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс ёс зүйтэй ажилтанг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороотой хамтарч мэргэжлээрээ бахархах, мэргэжлийн үнэ цэнэ, бусдад сайн үйлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Би ажилдаа дуртай”, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль ба хэрэгжилт” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг тус тус зарласан.



“Би ажилдаа дуртай” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд Тэргүүн байрыг Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникийн үзлэгийн эмч Я.Ганхүү шалгарч батламж, 50,000 төгрөг, дэд байрыг Яаралтай тусламжийн тусламжийн тасгийн туслах сувилагч Г.Амартүвшин шалгарч батламж, 30,000 төгрөг, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль ба хэрэгжилт” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд Тэргүүн байрыг Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, тандалт судалгааны албаны мэргэжилтэн Б.Батцэцэг шалгарч батламж, 50,000 төгрөг, дэд байрыг Асрамжийн клиникийн үзлэгийн эмч Б.Баттуяа шалгарч батламж 30,000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан.





Түүнчлэн “Эрүүл мэндийн салбарын ил тод, шударга байдал, ёс зүйг дэмжих” аян **санал хүсэлтийн хайрцагийг** эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдээр аялуулсан.

Сэтгэл заслын багтай хамтарч эмчлүүлэгч, үйлчлүүлэгч, ажилтнуудыг асуудалд хэрхэн эерэг /зөв, болох, бүтэх/ сэтгэлгээтэй хандах, аливаа зүйлийг сайн сайханаар бодож төсөөлөх, **хүний амьдралын гол үнэт зүйл нь эд хөрөнгө биш бие, сэтгэл,**

эрүүл мэнд гэдгийг ухааруулсан, ойлголт өгөх ярилцлага, эмчилгээний аргуудыг хэрэглэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээг иргэд олон нийтэд ил тод болгох, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, өвчтөний биеийн байдлыг ар гэрийнхэнд мэдээлэх “шилэн эрүүл мэнд”, шилэн эмнэлгийн ажлын туршлагыг нэвтрүүлэн байршлын лавлагаа мэдээлэл, ажлын цагийн хуваарь, галын гарцын байрлал, дотоод журам, товлотт үйлчилгээ зэргийг багтаасан ханын болон цахим урсдаг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн аюулгүй зорчих нөхцөл /эмнэлгийн ханын бариул/-ийг бүрдүүлэх зэргээр ажиллаж байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд эх, хүүхдийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг цахимаар болон газар дээр нь хүргэх замаар, төв эмнэлэг рүү шилжих урсгалыг сааруулж, ил тод нээлттэй үйлчилгээнд ахиц гарч байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/471 тоот тушаалаар Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Дээрх ажлын хүрээнд “Эрүүл мэндийн цаг” нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж, Эрүүл мэнд, эрхэм баян нэртэй фейсбүүк хуудсыг нээн ажилуулж байна. Эрүүл мэндийн чиглэлээр дагнан бичдэг сэтгүүлч, сурвалжлагчдын нэгдсэн “Эрүүл мэндийн яам” гэсэн фэйсбүүк групп, чатыг шинээр үүсгэн өдөр тутам яам болон салбарт болж буй үйл явдлын мэдээллийн зарыг түгээх, мэдээллээ тараах, санал бодлоо солилцож байна.

Мөн салбарын хэмжээнд жил бүр уламжлал болгон Эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөнийг “Нийгмийн эрүүл мэндийн дэмжих жил-2017” уриан дор зохион байгуулж /21 аймаг, 9 дүүрэг, харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтан хамрагдав. Зөвлөгөөнөөр үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ёс зүй, сонгон шалгаруулалт бусад хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, анхаарч ажиллах асуудлаар арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Мөнхжаргал, ажилтан Б.Тэрбиш нартай хамтран Гэр бүлийн радио- FM 104.5 радиогийн “930show” ярилцлагад оролцон Эрүүл мэндийн салбарын нөхцөл байдал, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд мэдлэг мэдээлэл олгов.

